

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/80/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2020 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: Цахим хаяг:

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг:

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |                                                                |
|----------|----------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын<br>Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                  |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                    |

|                                                                                                                                 |           |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>Аудитын гэрчилгээ .....</b>                                                                                                  | <b>3</b>  |
| <b>Аудитын тайлан .....</b>                                                                                                     | <b>4</b>  |
| 2.1. Оршил.....                                                                                                                 | 4         |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                                      | 4         |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                                           | 4         |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....                                                            | 5         |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод<br>хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 5         |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....                                                      | 5         |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....                                                                 | 5         |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....                                                                                    | 6         |
| 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                                                                     | 7         |
| 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....                                                                     | 7         |
| 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....                                               | 8         |
| 2.13. Шилэн дансны мэдээлэл.....                                                                                                | 8         |
| 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....                                                     | 8         |
| 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....                                                                                         | 8         |
| <b>Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....</b>                                                                                   | <b>10</b> |
| 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....                                                                              | 10        |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                                                                           | 10        |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                                                                                | 10        |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....                                                                | 10        |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                                                                            | 10        |
| 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....                                                                            |           |



## 2.1. Оршил

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Тэшиг сумын ЭМТ-ийн дарга Ц.Алтантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 01-нээс 2020 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дүгээр сарын 19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван аудит ХХК орхон салбарын аудитор Б.Дарханбат /Булган аймгийн төрийн аудитын газрын захиалгаар/ хариуцаж хэрэгжүүлэв.

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдаггүй түргэн шуурха хүргэхэд оршино.

Орхон сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хууль

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тэшиг сумын эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд си ти эс программ хангамж ашигладаг байна.

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 1 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 219,847.2 мянган төгрөгөөс тооцон 2,198,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 9,519.5 мянган төгрөгөөр тогтоосон.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,544.5 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                              | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт       |
|-------------------------------------------------------|-------------------|--------------------|----------------|
| Б                                                     | 1                 | 2                  | 3=2-1          |
| Мөнгөн хөрөнгө                                        | 0                 | 0                  | 0              |
| Авлага                                                | 1,554.8           | 4,776.5            | 3,221.7        |
| Урьдчилгаа                                            |                   |                    |                |
| Бараа материал                                        | 39,220.0          | 39,518.6           | 298.6          |
| Үндсэн хөрөнгө                                        | 301,142.3         | 301,166.4          | 24.1           |
| <b>Нийт хөрөнгө</b>                                   | <b>341,917.1</b>  | <b>345,461.6</b>   | <b>3,544.5</b> |
| Өр төлбөр                                             | 0                 | 2,168.5            | 2,168.5        |
| Засгийн газрын оролцоо<br>/Эздийн өмч/                | 341,917.1         | 343,293.0          | 1,375.9        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр<br/>хөрөнгө өмчийн дүн</b> | <b>341,917.1</b>  | <b>345,461.6</b>   | <b>3,544.5</b> |

Авлага дансны эхний үлдэгдэл 1,554.8 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд 811.8 мянган төгрөгийн авлага цуглуулж 4,033.6 мянган төгрөгийн авлага үүсч 4,776.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь төсвийн хөрөнгийн зөв зохистой удирдаж чадахгүй байгаа мэт харагдаж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 298.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 32,175.2 мянган төгрөгийн эм боох материал, 2,222.9 мянган төгрөгийн бичиг хэрэг, 10,461.3 мянган төгрөгийн аж ахуйн материал, 19,605.1 мянган төгрөгийн түлш, 2,757.0 мянган төгрөгийн засварын материал, 4,200.4 мянган төгрөгийн хүнсний материал нийт 71,456.1 мянган төгрөгийн бараа материал худалдан бэлтгэж 11,961.1 мянган төгрөгийн бараа материал хандив тусламжаар хүлээн авсан байна. Тухайн онд 83,118.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 0 мянган төгрөгийн бараа материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 34,910.0 мянган төгрөгийн үдсэн хөрөнгө хандив тусламжаар хүлээн авч, 36,318.8 мянган төгрөгийн элэгдэл тооцосонтой холбоотой.

Хандив тусламжаар 9,581.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр буюу иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан захирамжийн дагуу 2,459.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан бэлтгэсэн байна.

Тайлант онд бие бус хөрөнгөд өөрчлөлт буюу өсөлт, бууралт ороогүй байна.

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны өглөгийн данс эхний үлдэгдэл 0 мянган төгрөг байсан ба үйл ажиллагааны явцад 426,436.2 мянган төгрөгийн өглөг үүсэж үүссэн 424,267.7 мянган төгрөгийн өглөгийн төлж барагдуулан 2,168.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос өөрчлөгдөөгүй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн тайлант онд 443,734.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 425,882.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 95 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл              | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|----------------------------|------------|-----------|-------|------|
| Төвлөрсөн төсвөөс          | 379,242.4  | 380,054.2 | 811.8 | 100  |
| Орон нутгийн санхүүжилт    | 41,893.0   | 41,893.0  | 0     | 100  |
| Нийгмийн даатгалын сангаас | 3,935.6    | 3,935.6   | 0     | 100  |
| Нийт дүн                   | 425,071.0  | 425,882.8 | 811.8 | 100  |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2019 хөтөлбөрт зориулан 425,071.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 425,882.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 379,242.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 41,893.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 425,882.8 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 1 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 7,008.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0 мянган төгрөгийн алдааг залруулж, 0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 6,945.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 63.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 7,008.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6,945.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацааны эцэс 4,776.5 мянган төгрөгийн авлага, 2,168.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" албан шаардалгыг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн 63.3 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг шалгаж үзэх.

**2.13. Шилэн дансны мэдээлэл**

Тэшиг сумын эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шилэн данстай холбоотой мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн тайлгансан байна.

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан.

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй санал” дүгнэлт

Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

Бэлтгэсэн:

Аудитор

Д.Мягмарсүрэн

Огноо

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Огноо

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр

Огноо



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---------------------|----------------|-----------------|
| 2          | Мөнгөн хөрөнгө      | 0              | 0               |
| 37         | Нийт хөрөнгө        | 341,917,196.33 | 345,461,619.57  |
| 52         | Өр төлбөр эзний өмч | 341,917,196.33 | 345,461,619.57  |

**4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт               | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|------------------------|---------------------|-----------------------|
| 1          | Үйл ажиллагааны орлого | 360,005,500         | 475,975,765.58        |
| 2          | Үйл ажиллагааны зардал | 387,209,626.02      | 474,599,864.34        |

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт                             | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--------------------------------------|---------------------|-----------------------|
| 1          | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 359,193,650         | 425,882,850           |
| 17         | Нийт зарлага цэвэр зээл              | 356,643,650         | 424,449,950           |

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|------------|---------------------------------|-----------------------|----------------------|----------------------------------------|
| 2018.12.31 | 244,527,471.75                  | 153,829,101.35        | -56,439,376.77       | 341,917,196.33                         |
| 2019.12.31 | 244,527,471.75                  | 153,829,101.35        | -55,063,475.53       | 343,293,097.57                         |

**4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт     | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл   | Дүн        | Хувь |
|--------------|-------------|-------------|------------|------|
| Нийт зарлага | 443,734,600 | 425,882,850 | 17,851,750 | 95   |
| Санхүүжилт   | 425,071,000 | 425,882,850 | 811,850    | 100  |